

## ШУТИС-ИЙН БАГШ, АЖИЛТНЫ ЁС ЗҮЙН ЗӨВЛӨЛИЙН НЬ 2018-2019 ОНЫ ХИЧЭЭЛИЙН ЖИЛИЙН АЖЛЫН МЭДЭЭЛЭЛ

"ШУТИС-ийн Багш, ажилтны ёс зүйн зөвлөл" нь 2018-2019 оны хичээлийн жилийн ажлын төлөвлөгөөнд тусгагдсан ажлуудаа гүйцэтгэж, ШУТИС-ийн бүрэлдэхүүн сургуулийн тодорхой нэр бүхий багш, ажилтантай холбоотой доор дурьдсан ёс зүйн зөрчлийн талаар ирсэн өргөдөл, гомдлын асуудлыг судалж, дүгнэлт гарган их сургуулийн хэмжээнд мөрдөгдөж байгаа дүрэм, журмын дагуу арга хэмжээ авах саналыг сургуулийн захиргаанд тавьж шийдвэрлүүллээ. Үүнд:

- Суралцагчийг үг, хэлээр гутаан доромжилсон, дорд үзсэн;
- Албан тушаал эрх мэдлээ ашиглан дур мэдэн эсвэл хувийн шалтгаанаар загнах, айлган сүрдүүлсэн;
- Хамт ажиллагчидтайгаа хүндэтгэлгүй харилцаж, аливаа асуудлыг эв зүйгээр шийдэж чадаагүй;
- Оюутнаас мөнгө нэхэж, мөнгөн хэлбэрээр төлбөр авсан;
- Өөрийн давуу байдлаа ашиглан бусдыг сэтгэл зүйн дарамтанд оруулсан;
- Багш, оюутны хоорондын харилцаанд харилцан хүндэтгэлийг эрхэмлээгүй.

ШУТИС-ийн багш, ажилтнуудад ёс зүйн хэм хэмжээг мөрдлөг болгон ажиллахыг уриалж байна.

ШУТИС-ийн Багш, ажилтны ёс зүйн зөвлөл